

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН
2022 ОНЫ 12 ДУГААР ХУРАЛДААН**

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 12 дугаар хуралдааныг 10 цаг 25 минутад Нутгийн удирдлагын ордны II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 69.7 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны эхний хагас жилийн биелэлт, хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан хэлэлцүүлэх тухай	<p>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</p> <p>1. Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавар, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэлийн Ховд аймагт холбогдолтой шийдвэрүүдийн 2022 оны эхний хагас жилийн биелэлт, хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг хэлэлцэх явцад Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусгаж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан www.new.unelgee.gov.mn-д оруулан баталгаажуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Д.Бямбасүрэн, тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Оюунчимэг нарт үүрэг болгов.</p>

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР